

## Европын анагаах ухаан Монголд дэлгэрсэн түүхийг тодруулах нь

*Болд Ш., Болорцэцэг Ж.  
Шинжлэх Ухааны Академи,  
Анагаахын Шинжлэх Ухааны Түүх Судлаачдын Монголын Нийгэмлэг*

### Historical reviews of the European Medicine linkages into Mongolia

*Bold Sh., Bolortsetseg J.  
Mongolian Academy of Sciences  
Mongolian Society of Medical History Researchers*

Ancient Mongolia has accumulated experiences from generation to generation and created independent system of body structure, healing and healthy living by developing treatments for illnesses due to long term changes in natural phenomena, extreme climatic conditions, lifestyle habits, habits and war related diseases. The system has become a major part of the culture of Mongolia and has been enhanced by medical knowledge from other countries which include India, Tibet, and Chinese medicine, as well as study of European medicine that has not been sufficiently explored. There has been no research on history when this medical care disseminated in Mongolia and using source in research.

Therefore, this study was conducted to clarify when European medical knowledge arrived in Mongolia, its history and people who made contributions.

Historical facts of when European medicine was first "imported" in Mongolia, were recorded in policy of King Enkh-Amgalan of Manchu Qing Dynasty, the activities of religious missionaries from Europe to Manchuria and Mongolia and documents related to infectious diseases by Russian Consulate in Urguu. Based on these facts, European medical knowledge disseminated in Mongolia from 1703. This knowledge has been slowly spreading as a form of prevention from infectious diseases from the south through Beijing and Inner Mongolia as well as from the north through Buryatia to Ikh Khuree, and in some provinces.

Pp.51-57, Pictures 5, References 14

### Оршил

Эртний Монгол аймгууд урт хугацааны турш байгалийн юмс үзэгдлийн өөрчлөлт, цаг агаарын эрс тэс уур амьсгал, ахуй амьдралын онцлог, дадал хэвшил, дайн байлдааны уршгаас үүдэлтэй өвчин эмгэгийг эмчлэх аргыг үүдэн бүтээж, үеэс үед дамжуулан туршлагаа хуримтлуулсаар хүний биеийн бүтэц, эмчлэх, эрүүл амьдрах ухааны бие даасан тогтолцоог бий болгожээ. Энэхүү тогтолцоо нь хөгжлийн явцад Монголчуудын соёлын томоохон хэсэг болж, бусад орны анагаах ухааны мэдлэгээр баяжигдсаар ирсэн байна<sup>1</sup>. Бусад орны гэдэгт Энэтхэг, Төвөд, Хятадын анагаах ухаанаас гадна төдийлөн судлагдаагүй байгаа Европын анагаах ухаан орох бөгөөд уг анагаах ухааны эмнэлгийн тусламж Монголд хэдийд дэлгэрсэн

талаарх түүхийг судлах, эх сурвалжийг судалгааны эргэлтэд оруулах талаар хийгдсэн дорвитой судалгаа алга байна.

### 1. Европын анагаах ухааны дэлгэрлийн эхлэл

1687 онд Манжийн Энх-Амгалан (1662-1722 он) хааны засаглалын үеэр Францын Есүсийн нийгэмлэгийн гишүүдийн анхны элч нар болох Жоаким Бүвет (1656-1730), Лөүс ЛеСомт (1655-1728), Клод де Висделоу (1656-1737), Жан де Фонтаней (1643-1710), Жан-Франсуа Гербиллон (1654-1707) нар Манж Чин улсад иржээ. Энэ таваас Бүвет, Гербиллон нар Бээжин хотод үлдэхээр сонгогдов. Бээжинд үлдсэн 2 удалгүй эзэн хааны итгэлийг олж, арифметик, Эвклидийн элементүүд, практик геометр болон философи зэрэг европын мэдлэг, ухааныг заан сургах багш нар нь болсон байна.

<sup>1</sup> Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2016

Манжийн эзэн хаан таван жилийн туршид дээрх мэдлэгээс суралцаж байгаад 1692 онд 40 настай байхдаа хумхаа буюу чичрэг өвчнөөр өвджээ. Хаан хэдийгээр өөрийн ордны эмч нарт үзүүлж эм уусан ч сайжралыг олоогүй ажээ. Хааны өвдсөн нь барууны анагаах ухааныг ойлгуулах, бишрэлийг төрүүлэх, дэлгэрүүлэх чухал мөч завшаан болсон байна. Шашны элч нарын хяналт сайтай, үр дүнтэй эмнэл зүйн туршилтын дараа эзэн хааны амь насыг аварч, энэ мэдээг олон түмэнд зарлаж, хааны ордны доторх том харшаар шагнагдав. Эзэн хааны эмч нарын гурав нь буруу зөвлөгөө өгснийхөө төлөө шүүгдэн хөөгджээ.

Барууны анагаах ухаанаас үр шимийг нь хүртсэн Энх-Амгалан хаан гадаадын шинжлэх ухааныг ихэд сонирхож байв. Тэрбээр Бүветэд анатомийн тухай анагаах ухааны бүтээл бэлтгэхийг тушаасан байна. Улмаар төд удалгүй хаанд анатоми зааж эхлэв. Гэвч хэсэг хугацааны дараа Бүвет Франц руу явах болсон тул анатомийн хичээл заах ажил түр зогсжээ.

1698 онд Манжид ирсэн Доминик Пареннин (1665-1741) хэмээх өөр нэг элч уг ажлыг үргэлжлүүлэн дуусгасан байна. Тэрбээр орчуулагч төдийгүй математикч хүн байлаа. Шинжлэх ухааны мэдлэг, мэдээллийн талаарх эзэн хааны асуултад тун ч тодорхой, ухаалаг, сургамжтай хариулт өгдөг байснаараа тухайн үеийн судлаачдаас ялгардаг байжээ. Пареннин хүний биеийн бүтцийн талаарх мэдээллийг үргэлжлүүлэн цуглуулж анатомийн бүтээл бичиж эхлэв. Тэрбээр бүтээлдээ Пиер Дионисийн бичсэн тэр үедээ хамгийн нарийн, тодорхой бичигдсэн гэгддэг, европт анатомийн стандарт бүтээлүүдийн нэг байсан номыг сонгон авчээ. Харин жишээ зургийн хувьд Данийн Томас Бартолинийн номыг илүүд үзжээ. Анатомийн номыг таван жил бичсэн бөгөөд энэ хугацаанд эзэн хаан гурван хятадач, хоёр бичээч, хоёр зураач гарган өгч туслуулав. Уг бүтээл дууссаны дараа эзэн хаан хэвлэх зөвшөөрөл өгөхөөс татгалзав. Учир нь энэ бүтээл нь сайн боловсроогүй, шинэ зүйлийг хүлээн авах цаг нь болоогүй хүмүүсийн үзэж судлах энгийн нэг ном биш хэмээн үзсэн байна. Тэр ч бүү хэл гар бичмэлийг унших эрхийг хэдхэн хүмүүст олгон, тэдэнд номыг ордноос авч гарах, эсвэл тэмдэглэл хөтлөх зөвшөөрөл олгохгүй байв. Нийт гурван хуулбарыг гараар бичиж, Бээжин хотод нэг, нийслэлээс гаднах цэнгэлдэх ордонд нэг, гурав дахийг нь Манжийн өвөг дээдсийн нутаг Жехолд тус тус хадгалжээ. Харин Пареннин нэгэн тусгай хуулбарыг хийн


өөрийн гишүүн байсан Парис дахь Шинжлэх Ухааны Академид илгээжээ. Парисын хуулбар нь олон зууны турш европт байгаа цорын ганц хуулбар юм. Европт уг номыг “Манж анатоми” хэмээн алдаршуулж, олон арван судалгааны бүтээл хэвлүүлсэн байдаг.

Ер бусын сэтгэдэг, шинжлэх ухаанд дур сонирхолтой Энх-Амгалан хаан урлаг, шинжлэх ухааныг хөхиүлэн дэмждэг байсан ч “Манж анатоми”-ийн ач холбогдлыг төдийлөн ойлгож чадаагүйгээс уг номыг хэвлүүлээгүй хэмээн үздэг. Хэрэв хаан уг номыг хэвлүүлэн түгээсэн бол Европын анагаах ухаанд Везалийн “Фабрика”<sup>2</sup> (1543) хэмээх анатомийн ном хувьсгал хийсэнтэй адил тухайн үедээ Манж, Хятад, Монголын анагаах ухаанд хувьсгал хийх байжээ.

“Манж анатоми” номыг Монголчууд манж гар бичмэл эхээс нь “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” нэрээр монгол хэлээр орчуулж, гар бичмэлээр хэрэглэж байв. Хожим нь 1929 онд Өвөр Монголд “Зарлигаар тогтоосон хэти чиуван лу бичиг” нэрээр монгол бичгээр хэвлүүлсэн байна. Харин Монголд байсан “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” хэмээх хоёр боть, 6 дэвтэр бүтээлийг чухам хэдий үед орчуулсныг яг энэ цагт оноож хэлэх боломжгүй. Гэхдээ гүнзгийрүүлсэн судалгааны явцад тогтоох боломжтой юм. Магадгүй Фонтанейн хэлснээр: “Тэд өөрсдийн заах сургалтын материалаа татар<sup>3</sup> хэлээр бичдэг байсан. Дараа нь уг материалаа эзэн хаанд тайлбарлаж өгдөг бөгөөд хаан тэдний зааж байсан хичээлийг сайн ойлгож, бидний шинжлэх ухааныг улам биширч байлаа” хэмээсэнд үндэслэн Энх-Амгалан хааны үед монгол гар бичмэлээр байсан гэж таамаглах үндэс бий. Ямар ч байсан “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээл европын анатомийн бүтээлүүдэд суурилсан Өрнө-Дорны анагаах ухааны мэдлэгийг харгалдуулан бичсэн ховор ном бөгөөд Монголд Европын анагаах ухаан хүний биеийн бүтэц зүйн бүтээлээр дамжин дэлгэрч байсны гэрч хэмээн үзэх үндэстэй болно.

<sup>2</sup> Андреас Везал. De humani corporis fabrica. Хүний биеийн бүтцийн 7 боть ном.

<sup>3</sup> Монгол хэлийг хэлсэн бололтой. Гэхдээ зарим сурвалжид манж хэл хэмээдэг.



Зураг 1. “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийн манж, монгол хувилбар

## 2. Европын анагаах ухааны дэлгэрлийн өрнөл


Москвагаас Их Хүрээгээр дамжин, Бээжин рүү явж буй ван Головиныг дагалдан явж байсан Рейман эмч 1811 онд Монголд анх иржээ. Головин ван эмчийн хамт Их Хүрээнд түр саатан, орос ажилчид, зарим ноёд, түшмэдийг үзэж зөвлөгөө өгсөн байна. Энэ баримт Өргөөд гадаадын эмч үзлэг хийсэн тухай одоогоор олдоод байгаа эрт үеийн мэдээ хэмээн үзэж болохоор байна. Ер нь Монгол орноор Орос улсын судлаач нартай хамт явж байсан Оросын эмнэлгийн ажилтнаас монголчуудад эмнэлгийн тусламж үзүүлэх талаар ихээхэн анхаарал тавьж байсан баримтууд цөөнгүй бий.

Монгол үндэстэнд европ эмнэлгийн тусламжийг үзүүлж байсан өөр нэг нотолгоо нь шашин номлогч, элч Эдвард Сталлибрасс (1793-1884) түүний нөхөд юм. Тэрбээр анхны эхнэр Сара Робинсон Сталлибрассын хамт 1818 оны 3 дугаар сарын 30-нд Эрхүүд очиж Сэлэнгийн буриадуудтай уулзжээ. Гэвч тэд буриадуудтай хэл нэвтэрч төлийлөн чадаагүй байна. Учир нь Эдвард Сталлибрасс болон эхнэр Сара нарын монгол хэлний дуудлага маш ойлгомжгүй байж. Удалгүй Сара өвдөж буцсан бөгөөд өөр хэдэн элч нар ирж тэд хамтран 1920 онд Сэлэнгэд очиж өөрсдийн үйл ажиллагаагаа явуулжээ. Тэд нүүдэлчин буриад айлаар орж шашны номлолыг ухуулахын зэрэгцээ эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байв.



Зураг 2. Эдвард Сталлибрасс (1793-1884)

Эдвард Сталлибрассын дараа Жэймэс Гилмоур 1870 оны 5 дугаар сарын 18-нд Англиас Бээжинд ирж монгол хэл сурахын зэрэгцээ монголчуудтай танилцан Монголын талаар мэдээлэл цуглуулж улмаар Монголд очиж 15 сар амьдрав. Дараа нь Бээжинд буцан очиж хэсэг зуур саатсан байна. Энэ хугацаанд шашныг сурталчилахад ямар давуу тал, ямар сул тал байгааг нарийн тодруулж, Монголын нийгэмд чухал байр эзэлж байсан буддын шашны лам нартай хэрхэн ойртох болон эмч томилж туслуулах тухайгаа өөрийн тэмдэглэлдээ бичиж үлдээжээ.



Зураг 3. Жэймэс Гилмоур (1843-1891)

Түүнчлэн монгол ярианы болон бичгийн хэлийг гүнзгийрүүлэн сурч Монголчуудад европ эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэхийн тулд 1872 оны өвлийн турш Жон Доджийнийн “Бээжин эмнэлэг”-т эмнэл зүйн тохиолдлуудыг ажиглан, суралцаж өнгөрөөв. Түүний тэмдэглэлд: “Анагаах ухааныг гэртээ суралцаж байна. Анагаахын шинжлэх ухааны мэдлэгийг олж авах нь миний хувьд тун амаргүй тэгээд ч анагаахын мэргэжлийн хүмүүс номлогчоор явах хүмүүст анагаах ухааны бага зэрэг мэдлэгийг олгохдоо тийм ч дуртай биш юм. Энд ирэх хүртлээ би тэдэнтэй санал нэг байсан. Гэхдээ ирсэн хойноо нөхцөл байдал өөр байлаа” гэх мэтээр бичсэн байдаг.

Ингээд 1873 онд хоёр дахь удаагаа Монголд очиж хэрхэн ажилласан тухайгаа дараах байдлаар тэмдэглэн үлдээжээ. Би өдөрт дунджаар 12 миль явж 12 эрэгтэй, 3 эмэгтэй, 5 хүүхэдтэй ярилцаж, 8 өвчтөн эмчилж байлаа. Монголчууд шашны номлол сонсохоосоо илүү эм, эмнэлгийн тусламж үзүүлэхийг хүсдэг. Надтай уулзсан олон хүмүүс “Бээжин эмнэлэг”-ийг мэддэг байв хэмээн тэмдэглэсэн байна.

Гилмоурын эмнэлгийн тусламжтай холбоотой олон сонин зүйлүүд Монголчуудын дунд ихээхэн тархсан мухар сүсэгтэй холбоотойгоор тохиолдож байв. Жишээ нь: Нэгэн эр эхнэртээ Гилмоураас нүдний эм залжээ. Удалгүй эхнэрийнх нь нүд эдгэв. Гэтэл хэсэг хугацааны дараа нөхрийнх нь нүд өвдөн, эхнэрийнхээ хэрэглээд үлдсэн эмийг хэрэглэсэн ч туслах нь бүү хэл нүдний өвчнөөсөө болоод нойргүй хоножээ. Маргааш өглөө нь босоод нүдээ яасныг сайн шалгаадаг гэж эхнэрээсээ гуйв. Гэтэл эхнэр нь “Бурхан минь” нүдний цэцгийг чинь хагарчээ гэсэнд нөхөр нь хараал урсган (энэ хараал нь Гилмоурт чиглэгджээ) үүнээс болоод хараагүй боллоо гээд нүдний эмийн жижиг хайрцгийг чулуун дээр тавьж байгаад эвдэв. Тэгээд хэсэг хугацаанд айдас хүйдэст автсан ч цаг хугацаа өнгөрөх тусам нүд нь илааршиж урьдын адил хардаг болсон байна. Эмгэг жамын эхний үедээ байхад нүдний эм хэрэглэн улмаар хэрэглэсэн эмийн үйлдлээр үрэвслийн салсархаг, идээтэй нуух гарсан учрыг үл ухааран нүдний цэцгийг хагарсан гэж ойлгожээ. Оюун санааны баригдмал байдал, учрыг нь ухааж ойлгоогүй, хүний үгээр явдаг, шүтлэгийн хэтэрсэн хэлбэр нь дээрх байдалд хүргэсэн гэж үзэхээр байна.

Энэ мэтчилэн Гилмоур өвдсөн монголчуудад эмнэлгийн тусламж үзүүлж олон жилээр

Монголд амьдаржээ. Ер нь түүний илтгэлээс үзэхэд “Монголчууд христосын шашин гэхээсээ илүү эрүүл мэндтэй холбоотой асуудлаар хандах нь их байсан нь нотлогдоно. Тухайлбал: “1878 онд цөөн тооны хүмүүс эдгэхгүй өвчин байгааг олж мэдээд эм буй эсэхийг асууж байв. Тэдний зарим нь өвчин эмчлэгдэнэ ээ. Гагцхүү урьдчилан сэргийлж чадвал өвдөхгүй байх боломжтой хэмээдэг байв” гэх зэргээр бичжээ. Энэ баримтууд нь европын эмнэлгийн тусламжийг Монголчуудад үзүүлж байсны нэгээхэн гэрч юм.

### 3. Европын анагаах ухааныг Монголд нутагшуулагсад

Хаант Орос улсын Консулын газар 1861 онд Их Хүрээн (Өргөө)-д байгуулагдан Константин Николаевич Боборыкин 1861-1864 онуудад консулаар сууж байв.



Зураг 4. Константин Николаевич Боборыкин (1829-1904)

Константин Николаевич Боборыкин Их хүрээнд 1864 онд Консулын дэргэд эмчийн салбар нээж, тухайн үед Е.А.Осипов гэдэг эмч ажиллан, цэцгийн вакциныг консулын ажилчид болон Өргөөний ноёд, ихэс дээдэс, өндөр хэргэм, зэрэг, цолтой лам нарт вакцин тарих үйлчилгээ үзүүлж, эрүүл мэнд, халдварт өвчний талаар мэдээлэл цуглуулан Оросын жуулчин худалдаачдаар дамжин Монголоос халдварт өвчин Орост дамжин тархах аюулын тухай сэрэмжлүүлгийг Консулын газраас бичиж байв. Түүний эмчлүүлэгчдийн дотор Мэргэн ван, Цэцэнхан зэрэг дээдсүүд байлаа. Цэцэнхан Монголоос залуучуудыг Хаант Орост анагаах ухааны чиглэлээр суралцуулж, мэргэжил

эзэмшүүлэх хүсэлт гаргасан гэдэг. Үүний зэрэгцээ лам эмч, оточ нар Монголд цэцэг өвчин (бодо) өвчин газар авч байсны улмаас Оросын Консулын газрын эмч Е.А.Осиповт хүсэлт гарган цэцгийн эсрэг дархлаажуулах болон бусад өвчнийг Европын анагаах ухааны аргаар хэрхэн эмчлэхийг сурч байв.

Монголд халдварт өвчин дэгдсэн нөхцөлд Хүрээнд суудаг Оросууд эмч урьж авчрах, янз бүрийн эм захиалах, өөрсдөө эмнэлгийн анхан шатны мэдэгдэхүүн эзэмших зэргээр сурч ажиллан өөрсдийн эрүүл мэндээ хамгаалах талаар авч байсан арга хэмжээ нь Монголчуудыг европ зүгийн эмнэлэг, эмчилгээний аргатай гүнзгий танилцуулах үндэс болжээ. Үүний нэг тод жишээг “Хүрээн дэх Хязгаарын сайдын газрын ахлах түшмэл Дарьсүрэн: Та нарын бидэнд мэдээлсэн цэцгийн бодис их сайн зүйл юм тиймээс надад түүнээсээ олж өгөөч” хэмээн хүсэлт тавьж байснаас үзэж болно.

Их Хүрээнд сууж Оросын дараагийн консул Я.П.Шишмарев “Сүүлийн хоёр жилд Монголын ихэс дээдэс хүүхдүүдээ цагаан цэцэг өвчнөөс сэргийлэх вакциныг Консулын газарт ирж хийлгэж байна” хэмээн 1864 онд тэмдэглэжээ. Консул Я.П.Шишмарев Монголын нийслэл Өргөөнд оршин суугчдын эрүүл мэндийн талаар санаа тавин тодорхой арга хэмжээ авч байв. Тухайлбал: Монголд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм тааруу учраас халдварт өвчин: тиф, цэцэг, тэмбүү, нүдний өвчин их. Консулын газрын нэг эмч ажиллахад хүрэлцэхгүй байна. Тиймээс засгийн газартаа эмч ирүүлэх хүсэлт тавьж байв. Оросын засгийн газар энэ хүсэлтийг тун хойрго хүлээн авч чухамдаа Орос-Японы дайны нөлөө Өргөөд тусаж магадгүй хэмээн сэрэмжилж нилээд хойно Монголд эмч нар явуулах шийдвэрийг гаргав. Томилогдсон эмч нар Өргөөнд хүрэлцэн ирж Орос, Монгол, Манжийн амбаны түшмэдүүд, хятад цэргүүдэд үзлэг хийж эмчилгээ, үйлчилгээ үзүүлжээ.

1900-1902 онд Хятадад Ихэтуаны бослого гарахад Их Хүрээн дэх Оросын Консулын газрыг хамгаалах зорилготой цэргийн анги ирсэн бөгөөд тэнд цэргийн их эмч М.В.Сережников дагалдан иржээ. Тэрбээр Манжийн амбан болон манжийн цэргүүдийг эмчилдэг байсан учир Манжийн төрийн “Хос луу” одонгоор шагнагдаж байв. М.В.Сережников хамгаалалтын отрядын хамт буцсан ч тэр үед эрлэг болж байсан гоц аюулт халдварт цагаан цэцэг өвчин эсэргүүцэх ажилд томилогдон дахин ирсэн ажээ.

1901 оноос Өргөөд Оросын цэргийн ангиуд ирсэнтэй холбогдуулж мөн оны 4 дүгээр сард 15 ортой цэргийн эмнэлэг, 1902 оны 2 дугаар сараас цэргийн эмнэлгийн тасаг нээж, тэнд орос, монгол, хятад хүмүүс, манжийн амбан хүртэл үзүүлж байсан гэдэг. М.В.Сережников эмч Манжуурын төмөр зам болон Их Хүрээ, Ховд, Улиастайгаар дамжин, Хиагт зэрэгт амьдарч байсан оросуудын дунд худалдан авч буй ноос, арьс шир, тарваганы арьс зэргээр дамжин гоц халдварт өвчин тархаж болзошгүйг тэмдэглээд наймаачдын гол зангилаа болох Их Хүрээнд хүн ам олширч байгааг 1903 онд дурджээ. 1903 онд Сайн ноён хаан аймгийн нутагт цагаан цэцэг өвчин дэлгэрэхэд шинжилгээний ангийн эмч, орос болон монгол нийт 800 гаруй хүнд цагаан цэцгийн тариа хийж өгчээ.

Орос-Японы дайны үед М.В.Сережников эмч нутаг буцсаны дараа Хүрээнд бага эмч Корнеев томилогджээ. 1905 оны эцсээр цэцэг өвчний халдвар дахин дэгдэхэд Консулын газраас их эмч томилон ирүүлэхийг хүссэн байна. Энэхүү хүсэлтийн дагуу Оросын Амар мөрний цэргийн тойргийн их эмч Николай Николаевич Овсянников Монголд суурьшсан оросуудад үйлчлэхээр 1906 онд Хүрээнд хүрч ирээд 1909 оны гуравдугаар сарын 15 хүртэл ажиллаж байсан тухай баримт Алс дорнодын цэргийн тойргийн архивт хадгалагдан үлджээ.

Тэр үед Их хүрээн дэх Оросын консулын дэргэд байнга суух болсон их эмч Овсянниковоос 1907 оны 3 дугаар сарын 21-нд бичсэн нэгэн мэдээндээ өгүүлсэн нь: “Би 1906 оны 2 дугаар сарын 19-өөс эхлэн мөн оны 10 дугаар сарын 1 хүртэл Их хүрээнд нийт 13749 хүнд зөвлөгөө өгсөнөөс Монгол 10803, Орос болон гадаадын 2910 хүнд тус тус үзлэг хийж элдэв өвчнийг эмчиллээ” хэмээжээ. Энэ эмч өвчтэй хүмүүсийн гэрээр өдөр, шөнө ялгаваргүй явж эмчлэн эдгэрүүлж байсан байна.

Н.Н.Овсянников эмч 1.5 жил ажиллаад нутаг буцсаны дараа Консулын дэнжид 1909 оны 10 дугаар сарын 3-нд Их хүрээнд байсан орос, буриад, хятад, монгол, төвөд хүмүүсийг үнэ төлбөргүйгээр эмчлэх нэгэн жижиг эмнэлгийг байгуулжээ. Энэхүү эмнэлэгт эмч С.Б.Цэвэгтарва ажиллаж байв. Оросын дипломатч, түүхч Н.Майский “Орчин үеийн Монгол” номондоо (1921) “Монголчуудын бие чийрэг, хагалгаа хөнгөн даадаг, наркоз бараг шаардагдахгүй, оёос нь амархан түргэн эдгэрнэ ... гээд Өргөөд 10 жил ажиллаж байгаа буриад доктор Цэвэгтарва (С.Б.Цыбиктаров) гуайн

хэлж байгаагаар ердөө 5 удаа л дифтеритэй тааралдаж байсан, гэхдээ зөвхөн Оросын колонистуудын гэр бүлд тохиолдож байсан гэж мэдээлэв” гэж тэмдэглэжээ.

Санжмятав Будажапович Цыбиктаров, монголчилвол Санжмятав Буджав Цэвэгтарва гэсэн төвөд гаралтай үг. Цэвэгтарва (төвөдөөс орчуулбал Насны хэмжээг тонилгогч) нь Петербургийн Цэргийн анагаах ухааны дээд сургуулийг амжилттай төгсөж буриадууд дотроос их эмчийн диплом гардан авсан анхны хүмүүсийн нэг болжээ.



Зураг 5. С.Б.Цэвэгтарва өөрийн эхнэрийн хамт

Петербургийн хараагүйчүүдийн асрамжийн газраас нүдний хоёр отрядыг Монгол руу илгээсэн байна. Уг отрядын зардалд хаант Оросын Сангийн яамнаас 12000 рубль гаргажээ. Энэ үйл ажиллагаа Цэвэгтарвагийн шууд санаачилгаар хийгдсэн байлаа. Монголд орж ирсэн Европ боловсролтой эмч нар ихэнх нь цэргийн эмч нар байв. Цэвэгтарва ч Оросын консулын цэргийн эмч байсан бөгөөд түүний үйлчилгээний хүрээ консулын төдийгүй Монголыг хамарч чаджээ.

Монгол ахуй соёлыг сайн мэддэг Цэвэгтарва тухайн үеийн Орос-Хятадын банкны захиргаа болон “КоковинбаБасов” компаниас хандивласан 4000 рублиэр дүнзэн байшин худалдаж аваад түүнийгээ эмчийн өрөө, мэс засал, аптека, эмэгтэйчүүд, оросууд, монголчуудын тус тусын тасагтай жинхэнэ эмнэлэг байгуулжээ. Оросын консул Я.П.Шишмарев 1909 оны аравдугаар сарын 24-нд Хаант Оросын Гадаад явдлын яаманд “1909 оны аравдугаар сарын 3-ны өдөр

эмнэлэг албан ёсоор нээгдэв” гэж мэдээлсэн байдаг. Эмнэлгийн нээлтэд Манжийн амбан бараа бологчдынхоо хамт оролцсон байна.

Цэвэгтарва 1909 онд ганцхан сарын дотор амбулаторидоо 1100-1400 гаруй өвчтөн хүлээн авч үзлэг хийсний 200-гаад нь орос, 300 нь хятад, 700-гаад нь монгол хүн байв. 1909 оны 5-12 сар хүртэл эмнэлэгт үзүүлсэн хүний тоо 2611 байсан бол 1910 онд хэвтэж эмчлүүлэгсдийн тоо 1767, үйлчлүүлэгчдийн тоо түүнээс хамаагүй олон болсон байв. 1911 онд хэвтэж эмчлүүлэгчид 4458, үзлэгт хамрагдагсад 10261 байсны 433 нь орос, 3399 нь хятад, 6429 нь монгол байжээ. 1912 онд 6703 хүн хэвтэж эмчлүүлжээ. Цэвэгтарва жирийн монгол иргэдээс Монголын дээдсийн хүрээлэн болон Өвөр Монголд хүртэл нэр алдар нь түгжээ.

Өвчин эмгэгтээ шаналж зовсон угсаа гарал нэгтэндээ анхаарал халамжтай ханддаг Цэвэгтарва Европын анагаах ухааны нэр хүндийг лам нар болон тэднийг бишрэн шүтэгчдийн нүдэн дээр дөрөвхөн жилийн дотор зохих хэмжээнд хүртэл өргөж чадсан байна. Одоо зөвхөн жирийн монголчууд төдийгүй хутагт хувилгаад, хан ван нараас эхлээд мяндагтан лам нарын зэрэг хүн амын дээд давхаргынхан ч Цэвэгтарвад хандах нь цөөнгүй боллоо гэжээ.

Өргөөгийн эмнэлгийн тухай, “Оросын бүдүүн эмчийн” тухай домог мэт яриа Өргөө хавийнхны төдийгүй Өвөр Монгол хүний амнаас ч сонсч болно” хэмээжээ. Бароны цэрэгт амь үрэгдтэлээ Монголд 12 жил ажиллахдаа Цэвэгтарва Европын анагаах ухаанд итгэх итгэлийг зөвхөн өвчтөндөө төдийгүй маарамба-лам нарт ч өгч чадсан байдаг. Тэрээр лам нарын хүсэлтээр залуу лам нарт хүний биеийн бүтцийн хичээл зааж байсан байна. Дээрх байдлаас үзвэл С.Б.Цэвэгтарва Монгол Улсад Европын анагаах ухааныг Монголд нутагшуулахад өөрийн хувь нэмрээ оруулсан эмч юм.

С.Б.Цэвэгтарваан дараа Их хүрээнд 1921 онд Унгарын харъяат их эмч Раднот-Андор гэдэг хүн ирсний дараа хуучин өргөн чөлөөний Бээжин Содномдаржаагийн пүүсний зүүн үзүүрт нэгэн шавар байшинд европ, төвөд хосолсон эмнэлгийн газар нээж, түүнд Санжаажамц, Хайдав, Дамбийням, Лэгцэг гэдэг арваад маарамба нар ажиллаж мөн эмнэлгийн дэргэд төвөд эмнэлгийн нэгэн жижиг эмийн сан ажиллаж, түүнд лам Лувсан-Цэвэг, Их хүрээний манба дацангаас залуу эмч Рэгзэн, Шархүү нар хамт ажиллаж байжээ. Энэ эмнэлэг Монгол Улсын болон нийслэл Улаанбаатар хотод

байгуулагдсан орчин цагийн анагаах ухааны анхны эмнэлэг байлаа.

Орос, буриадын эмч нараас гадна 1909 онд Унгарын харъяат Пинцел, Зиберт зэрэг хүмүүс европын эмийн сан ажиллуулж түүнээс эм авагчид өдөр, шөнөгүй цувардаг байжээ.

Европын анагаах ухаан Монгол оронд анх “импортлогдсон” түүхэн баримтууд нь Манж Чин гүрний хаан Энх-Амгалан түүний бодлого, Европоос Манжид болон Монголд ирсэн шашны элч нарын үйл ажиллагаа, Хаант Оросын Консулын газар Өргөөд нээгдсэн үйл хэрэг, халдварт өвчтэй холбоотой баримт бичгүүдэд тэмдэглэгдэж үлдсэн байна. Эдгээр баримтуудад үндэслэн Монголд Европ зүгийн анагаах ухааны мэдлэг 1703 оноос эхлэн дэлгэрэх үндсээ тавьжээ. Энэ мэдлэг урьд зүгээс Бээжин, Өвөр Монголоор, Хойд талаас Буриадаар дамжин Их Хүрээнд төвлөрөн улмаар зарим аймаг хошуунд халдварт өвчнөөс сэргийлэх хэлбэрээр аажим дэлгэрчээ.

#### Ашигласан хэвлэл

1. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Дөрөвдүгээр боть. УБ, 2013
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын анхдугаар Үндсэн хууль. УБ, 1924
3. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын анхдугаар Үндсэн хууль. УБ, 1924
4. Гэрэлмаа. Б. “Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг” бүтээлийн эх сурвалж, агуулгын зарим онцлог. Магистрын зэрэг горилсон дипломын ажил. УБ, 2017
5. Дээрээс тогтоосон дүрс тус бүрийг бүртгэсэн бичиг. Хэвлэлд бэлтгэсэн Ринчен Б, ШУАХУ, УБ, 1971.
6. Майский И. Орчин үеийн Монгол. (Автономит Монгол XX зууны гараан дээр), УБ Хэвлэлийн компани, 2001.
7. УТТ. Архив Ф-1, Д-1, ХН-34 х-1
8. УТТ. Архив Ф-1, Д-2, ХН-64
9. 2005-2008 оны эрдэм шинжилгээний тайлан. МУ-ын ШУА, УБ, 2009
10. Андреас Везал. De humani corporis fabrica. Хүний биеийн бүтцийн 7 боть ном.
11. Bold Sh. History and Development of Traditional Mongolian Medicine. УБ, 2013
12. Charles C. Ragin. The Comparative Method: Moving Beyond Qualitative and Quantitative Strategies. University of California Press, 1987. p. 12-16
13. Dergici toktobuha ge ti ciovon lu bithe. Гар бичмэл манж судар
14. French Jesuits and the “Manchu Anatomy” – how missed the Vesalian Revolution. CMAJ•JAMC. 1974 Sep 21; 111(6): 565-6, 568.